

“МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООН”-НЫ ХЭЛИЙГ СУДЛАХ АСУУДАЛД

Ш.Чоймаа*

Монгол туургатны хэл, түүх, соёл, уран зохиолын гайхамшигт дурсгал “Монголын Нууц Товчоон”-ыг өрнө дорны үе үеийн судлаачид, өөр өөрийн судалгааны чиг хандлагаас буюу бүхэлд нь судалсаар олон арван жил болж, “МНТ”-ы судлал хэмээх монгол судлалын нэгэн салбарыг буй болгожээ. “МНТ”-ыг ийнхүү ихэд анхаарах болсон гол шалтгаан гэвэл:

1. Дундад зууны түүхэнд товойн гарч ирсэн Их Монгол улс, түүнийг үндэслэн байгуулагч эзэн богд Чингис хааны намтар түүхийг судлаач нар төдийгүй, ерийн уншигчид ч шимтэн сонирхож, үнэн зөвийг олж мэдэхийг хүсдэг ажээ.
2. Монголын судлалын олон чиглэлээр сурч, судалж байгаа хүн бүхэн, аль нэг сэжүүрээрээ “Монголын Нууц Товчоон”-той гарцаагүй учирдаг. Мөн үе үеийн судлаачдын “МНТ”-ы эрдэм шинжилгээний латин галиг эх, орчин цагийн монгол хэлний хөрвүүлэг, тайлбар, олон хэлний орчуулга, тухайлсан судалгаа зэргийг үзэж мэдэх шаардлагатай болдог.
3. Аливаа үндэстэн угсаатныг бүх талаар судлахын уг үндэс, гол түлхүүр бол тухайн үндэстний хэлийг нь сайн мэдэх, хэл сэтгэхүйн онцлогийг нь сайтар ухаарах явдал юм. XIII, XIV зууны үеийн Монголыг судалъя гэвэл, тухайн үеийн монгол хэл, бичиг, үгийн сангийн тэр үеийн утгыг сайн мэдэх ёстой. Үүний тулд зайлшгүй “МНТ”-ы хэлтэй учрах болно. “МНТ”-ыг судалгаандаа ашиглахдаа, юуны өмнө уг хэллэг бүрийн эртний утга, найруулгын өнгө аяс зэргийг сайн мэдэж чадвал, зөв дүгнэлт хийж чадна. Үүний нэг жишээг түүхч А. Пунцагийн сүүлийн үеийн судалгаанууд, тухайлбал, “МНТ”-ы 112-р зүйлд гарах “зориулав”¹ хэмээх үгийн тайлбараас үзэж болно.
4. Монголчууд өөрийн бичиг үсгээрээ олон зууны туршид, монголын түүхэд хамаарах чамгүй олон сурвалж бичгийг бүтээн туурвисан бөгөөд тэр бүгдийн уг язгуур нь “МНТ”-той шууд болон дам холбогддог. Тийм учраас, Монголын түүхийг сонирхон судлагч хүн бүхэн, юуны өмнө “МНТ”-той танилцаж, улмаар бусад түүхэн сурвалжийг харьцуулан үздэг. Энэ мэт зүйл зүйлийн учир шалтгаанаас “МНТ”-ы судлал улам бүр гүнзгийрэн хөгжиж байна. “МНТ”-ы зөвхөн хэлний талын судалгааны сүүл үеийн байдлыг авч үзвэл хоёр зүйлийн гол онцлог ажиглагдаж байна. Үүнд:

* МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

¹ А.Пунцаг “Монголын Нууц Товчоон”-ы судалгаа, УБ, 2008. т 160-164

1. “МНТ”-ы хэлийг олон талаас нь, хэлний олон төвшинд нь судлах ажил эрчимтэй болжээ. “МНТ”-ы үг хэллэг, зарим өгүүлбэр, эхийн зарим хэсэг, зарим үгийн үгийн сангийн утга, үг бүтээх дагавар, үг хувилгах нөхцөл зэргийг улам бүр тогтолцоотой судлах болж байхын хамт харь хэлээр орчуулах, эрдэм шинжилгээний шинэ латин галиг хийх, анхны монгол бичгийн эхийг тухайн үеийн үсгийн тиг, зөв бичих ёс, хэлзүйн онцлогоор нь сэргээх, орчин цагийн монгол хэлэнд дахин хөрвүүлж, эртний үг хэллэгийн тайлбар хийх, хожмын монгол түүхэн сурвалжуудтай эх бичиг судлалын үүднээс харьцуулах гэх мэт судалгаа үргэлжлэн хийгдэж, судалгааны чанарын төвшин ч сайжирчээ.
2. “МНТ”-ы хэлийг судлахдаа, монгол үг хэлийг хятад үсгээр галигласан эх, түүний хятад орчуулгад л гол анхаарлаа тавьж хандуулдаг байсан бол өдгөө эрт болон дунд үеийн монгол хэл, монгол хүний хэл сэтгэхүйн онцлогийг сайтар анхаарч, “МНТ”-ы анхны уйгуржин бичгийн эхэд тухайн үг ямар онцлогтой бичигдсэн байж болох вэ? тийм өвөрмөц онцлогтой эхийг 14-р зууны сүүл хагаст хятадаар галиглагч бээр хэр зэрэг зөв уншсан бол?” гэх зэрэг асуултыг бодолхийлж судалдаг болжээ.

Мөн энд дурдах ёстой нэгэн зүйл бол монголчуудын буюу өөрсдийнх нь судалгаа тун эрчимтэй боллоо. Энэ тухай Японы нэрт монголч эрдэмтэн Ш.Озава бээр “МНТ”-ыг дөч гаруй жил судалснаа дурсан бичихдээ “*Миний бие эдгээр (өмнөх судлаачид Ш.Ч) аугаа их урьдасын жигүүр далавчин доор багтан, “Нууц Товчоон”-ы хэл лүгээ алхалж явтал, цагийн хүрд ч хайр найргүй эргэж, Шиёвагийн Хэйсэй болж хувирлаа. Цагийн урсгалыг дагалдан, “Нууц Товчоон”-ы судлалд ч шинэ гэрэл гэгээ тусав. Тэрхүү гэгээ бол монголчуудын өөрийнх нь судалгаа болно*”² хэмээжээ. Энэ бол монголчуудын хийсэн “МНТ”-ы талаарх судалгаа зохих амжилтад хүрч байгааг харуулж байна.

“МНТ”-ы хэлийг судлах асуудалд гэсэн сэдвээр өөрийн хийсэн болон ажигласан зүйлдээ түшиглэж, хэдэн санааг та бүхэнтэй хуваалцъя.

1. Аливаа түүхэн сурвалжийг судлахад, зохиогчийг тодорхойлохыг юун түрүүнд чармайдаг. Энэ нь ч зүйн хэрэг бөгөөд үе үеийн судлаачид “МНТ”-ы зохиогчийн тухай санал бодлоо нийтэлж ирсэн боловч, нэгдэлтэй үр дүнд хүрээгүй л байна. 1990 оны эхээр, миний бие “МНТ”-ы зохиогчийн үгэнд гарах “бид” хэмээх үгийг мөрдөн нэгэн илтгэл хийж билээ. Тэр цагаас хойш, “МНТ”-ыг дахин давтан үзэж судлах явцдаа олж мэдсэн зүйл бол “МНТ”-ы зохиогчийг тодлохын тулд, уг зохиолын бод биеийг сайн судалж, эхийн төвшинд хэл найруулга, зохиогчийн хэрэглэсэн үг хэллэг бүрийг нарийн шинжлэх хэрэгтэй болохыг ухаарсан. Зохиогчийн хэлж дуудаж заншсан, өөрт нь зуршил болсон үг хэллэг нь санамсаргүй цаасанд бууж, тэр нь учир шалтгаан нөхцөл байдалд үл зохилдох хэсэгт ч тохиолддог юм. Жишээ нь:

“МНТ”-ы 68-р зүйлд:

“... yisügei-ba'atur ... ögülerün **čaqa minu** mönglik ... bi kō'ū-ben temüjin-i güriget-te talbiju irerün ja'ura tatar irgen-e oyisulaqda'a bi ... **kō'ū minu** temüjin-i ötörken otu abču ire **čaqa minu** mönglik kē'et nökciba ...” (Есүхэй баатар ... өгүүлрүүн, **чагаа минь**, Мөнлиг ... би хөвүүгээ, Тэмүжинийг хүргэдэд тавьж ирэрүүн (ирэхдээ Ш.Ч) зуур Татаар иргэнээ ойслогдоо би ... хөвүүг минь, Тэмүжинийг үтэрхэн одож авч ир, **чагаа минь**

² Ш.Озава “Монголын Нууц Товчооны ертөнц”, орчуулсан Б.Баярмэнд, хянан тохиолдуулсан Чойжунжав, УБ, 2002. т.191.

Мөнлиг хэмээгээд нөгчив) хэмээн гарах бөгөөд “МНТ”-ы 69-р зүйлд: “yisūgei - ba'atur-un ūge-yi busi ūlū bolqan mōnglik otču ... mōnglik-ečige temūjin-i a[b]ču ireba ...”³ (Есүхэй баатарын үгийг бус үл болгон, Мөнлиг одож ... Мөнлиг эцэг Тэмүжинийг авч ирэв) Өмнө эш татсан хэсэгт Хонхотаны Чарахагийн бага залуу хөвгүүнийг Есүхэй баатар “чагаа минь” (нялх бага үр минь гэсэн утгатай) хэмээн дуудах нь зүйн хэрэг боловч, нэг хоёрхон хоногийн дараах хэргийг бичихдээ зохиогч бээр “Мөнлиг эцэг Тэмүжинийг авч ирэв” хэмээсэн нь нөхцөл байдалд огт нийцэхгүй бөгөөд харин Чингис хаанаас эхлээд, ойр тойрны бүх хүмүүс Мөнлигийг эцэг хэмээн дууддаг болсон хожмын зуршлаараа санамсаргүй бичихсэн хэрэг юм.

Мөн үүнтэй төстэй зүйл “МНТ”-ы 112-р зүйлд: “... belgūtei-noyan merkidei ele yasutu gū'ūn-ni eke-yi minu abčira ke'eju qodolitqu būle'e”⁴ (Бэлгүтэй ноён Мэргидэй л яст хүнийг эхийг минь авчир хэмээж годилдох бүлгээ) гэж буй. Энэ хэсгийн үйл явдал бол 1178 оны орчим буюу Тэмүжинийг 17 настай байхад нь Гурван Мэргид довтолж, эрт цагийн өш авахаар ирж, Бөртэ Үжинийг олзлон одсоны хойно, Тэмүжин бээр Ван хаан, Жамуха хоёрын тусламжтайгаар Гурван Мэргидийг довтолж, Бөртэ Үжинийг олж авч байгаа үеийн хэрэг юм. Энэ үед Тэмүжиний дүү Бэлгүтэйг ноён хэмээн дуудах ямар ч үндэс, учир шалтгаан байхгүй. Бас л хожмын цагт, зохиогч тэргүүтэн бээр цөм Бэлгүтэй ноён хэмээдэг байсан нь зохиогчийн аманд дадал болсноос шалтгаалсан хэрэг юм.

Мөн “МНТ”-ы 96-р зүйлд Тэмүжин, Хасар, Бэлгүтэй гурав Цотан эхийн инжид өгсөн хар булган дахыг аван одож, Туулын хар түнд буй Тоорил ханыг зорин очсон тухай гардаг. Энэ хэсэгт Хэрэйдийн Тоорил ханыг Ван хан хэмээсэн нь бас л зохиогчийн өгүүлж дадсанаараа бичсэн зүйл болно. Учир нь “МНТ”-ы 134-р зүйлд “Вангин чинсан Мэгүжин сүүлтийг алжухуй хэмээн мэдээд, маш баясч, Чингис хаанд Жаут хури нэр өгөв. Хэрэйдийн Тоорилд Ван нэр тэнд өгөв. Ван хан нэр, Вангин чинсангийн нэрийдсэнээр тэндээс болов” хэмээн гардаг болой.

Өмнө эш татсан гурван жишээнд, бага залуу Мөнлигийг “эцэг” гэх ба мөн бага залуу хөвгүүн Бэлгүтэйг “ноён” хэмээсэн хийгээд Хэрэйдийн Тоорил ханд Алтан ханы Вангин чинсан ван нэр өгсөнөөс аль өмнө Ван хан хэмээсэн нь яах аргагүй зохиогчид хамаарах, бас анхаарах зүйл мөн. “МНТ”-д, I биеийн олон тоог заах “бид” хэмээх үгийн хэлзүйн хэлбэрүүд цөөнгүй удаа зохиогчийн үгэнд гардаг. Эдгээр баримтыг “МНТ”-ы эх бичгийн хам сэдвийн хүрээнд, хэрэг учрын өгүүлэмжийн нөхцөл байдалд нь нягтлан үзвэл, “МНТ”-ы зохиогч (гол зохиогч) бол Чингис хаантны ойр дотнын хүн, олон он жилд олон хэрэг явдалд хамт байсан хүн болох нь илт байдаг.

2. “МНТ”-ы хэлийг сайтар судлахын тулд “МНТ”-ы анхны эх бичгийн үсгийн тиг, зурлага, зөв бичих дүрмийн онцлог, хэлзүйн онцлог зэргийг сэргээн төсөөлж, түүндээ тулгуурлан “МНТ”-ы хятад галиг эхийн ташаарлыг олж, залруулж болно. Ийм чиглэлийн судалгааг Ихмянгадай Иринчин, Бүрэнбат, Ш.Озава зэрэг эрдэмтэд хийж эхэлсэн билээ. Профессор Ш.Озава бээр “МНТ”-ы 169-р зүйлийн нэг өгүүлбэрийг Лу. “Алтан товч”-той харьцуулан доорх мэт үзүүлжээ.

[SHM] ... merkidei - čaqa'an aman - čaqa'an - ke'er

[LAT] ... merged-dei čayan aman čayan keger

[SHM] ... qoyar-i bariju abčira huyaju

³ Rachewiltz Igor de, *Index to the Secret History of the Mongols*, Bloomington, 1972. т. 26-27

⁴ мөн номын т. 46

[LAT] ... qoyar-i bariju abču ire uyaju

[SHM] ... + ... sōni erte morilaqu ke'ejū'ūi

[LAT] ene sōni erte morilasu kemejūkūi ...

Үүнийг тайлбарлахдаа “МНТ”-ы хятадаар галигласан уул зохиол болон Лу. “Алтан товч” нь гайхмаар адилхан байна. Энэ хоёрын ноцтой зөрөө нь “*morilaqu*”-тай тохиролцох “*morilasu*” болно. Хойно, өмнөх үгийн харьцаанаас үзвэл, Лу. “Алтан товч”-ийн “*morilasu*” зөв болох нь тодорхой байна. Энэ нь “МНТ”-ы хятад галиглал уйгуржин монгол үсгийн уг эхийн суурь дээр хийгдсэн гэсэн төсөөллөөр эхлээд тайлагдана. Уйгуржин монгол үсгээр “*morilasu*” гэж бичсэн энэ үгийг хятадаар галиглагч “*morilaqu*” гэж буруу уншаад 秣^{ᠮᠣᠯᠢᠰᠤ}驪^{ᠮᠣᠯᠢᠰᠤ}刺^{ᠮᠣᠯᠢᠰᠤ}忽^{ᠮᠣᠯᠢᠰᠤ} гэж галигласан байна. “МНТ”-ы хятад галиглалд энэ мэтээр түүний эх зохиол уйгуржин монгол үсгээр бичигдсэн байвал л сая 速^{ᠰᠤ} su болон 忽^{ᠬᠤ} qu - гийн алдаа үүснэ. Дөрвөлжин үсгээр бичсэн эх зохиолоос галиглахад хүрвэл яасан ч ийм эндүүрэл гарахгүй. ᠰᠤᠬᠤ ᠰᠤ ᠰᠤ ᠰᠤ хэмээхийг ᠰᠤᠬᠤ ᠰᠤ ᠰᠤ ᠰᠤ гэж буруу унших явдал байж болшгүй юм. Тиймээс “МНТ”-ы хятад галиглалын суурь болсон ном нь дөрвөлжин үсгээр бичигдсэн биш гэдэг нь баттай юм. Бас уулаасаа хятад үсгээр бичигдсэн дэвтэр байсан гэдэг Козины үзэл ч тогтоож чадахгүй нь тодорхой байна”⁵ хэмээн бичсэн билээ. Профессор Ш.Озавагийн энэ үндэслэл тайлбарыг үнэн зөв хэмээн үздэг тул дэлгэрэнгүй эш татлаа. Уйгуржин монгол бичгээр бичсэн эхээс хятадаар галигласан болохыг батлах жишээ олон бий. Жишээлбэл:

“МНТ”-ы 257-р зүйлд Чингис хаан Сартуул иргэнд дайлсан тухай гарах бөгөөд ямар ямар хот балгадыг эзэлсэн тухай өгүүлдэг.

“МНТ”-ы 258-р зүйлд:

“... tolui-yi iru *isebūr* teri'ūten olon balqat bawutqun ke'en ilēba činggis - qahan ōbesūn udarar - balaqasu bawuba ...”⁶ (Толуйг Ирү, Исэбүр(Нисабур Ш.Ч) тэргүүтэн олон балгадад буугтун хэмээн илгээв. Чингис хаан өөсөөн Ударар (Отрор Ш.Ч) балгаст буув.) хэмээн гардаг. Энд гарч байгаа Дундад Азийн хот балгадын нэр нь XIV зууны сүүл үест Бээжинд аж төрж байсан бичгийн хүмүүст танил бус нэр тул уг эхэд хэрхэн бичсэнийг үсэгчлэн уншихаас өөр аргагүй. Тэдний гарт байсан эхэд хэмээн бичсэнийг үсэгчлэн дуудсанаар “*isebūr*”, “*udarar*” хэмээн хятадаар галиглажээ. Хятадаар “*isebūr*” хэмээн галигласан энэ хот нь одоогийн Туркмений өмнөт хэсэг Ираны хойд хэсэг болон Афганистаны баруун хойд хэсгийг хамарсан Хорасан хэмээх тэр үеийн улсын нийслэл Нишапур хот юм. Хэрвээ хятадаар галиглагч энэ хотын нэрийг мэддэг байсан бол “*nisabur*” (Нисабур) хэмээн дуудах нь лавтай. Нөгөө хотын нэрийг “*otrar*” гэлгүй, “*udarar*” хэмээн галигласан нь ч мөн адил. Энэ хоёр үгийн эхний үеийг “i” буюу “ni” мөн “o” буюу “u”-гаар унших бололцоотой байснаас энэ алдаа гарчээ.

Мөн “МНТ” - ы 49-р зүйлд:

“qutu[q]tu-yürki-yin kō'ūt seče-beki taiču qoyar būle'e” (Хутагт Юрхийн хөвүүд Сэчэ-бэхи, Тайгу хоёр бүлгээ) хэмээн бичсэн атлаа 192-р зүйлд: “jürkin-ū sorqatu-jürki-yin kō'ūn sača-beki taiču qoyar ...” (Жүрханий Сорхату Жүрхийн хөвгүүн Сачабэхи, Тайчу хоёр)⁷ хэмээн бичжээ. Энэ хоёр хэсэг жишээнд нэг л нэрийг “yürki” ~ “jürki”, “seče” ~ “sača”

⁵ Ш.Озава “Монголын Нууц Товчооны ертөнц” УБ, 2002. т. 43

⁶ Rachewiltz Igor de, *Index to the Secret History of the Mongols*, Bloomington, 1972, 155-р тал

⁷ Rachewiltz Igor de, *Index to the Secret History of the Mongols*, Bloomington, 1972, 21-р тал

хэмээн хоёр янзаар бичсэн нь “МНТ” -ыг хятадаар галиглагч бээр уйгуржин монгол бичгээр байсан эхийг уншин буулгасны баримт юм. Энэ жишээг профессор Баяр, Ш. Озава нар ажиглан тэмдэглэсэн байдаг Лу. “Алтан товч”-д “*seče-beki*” хэмээх нэрийг яг энэ тохиолуудад “*sečen – beki*” хэмээн бичсэн байдаг билээ. Үнэхээр “*сэцэн*” хэмээсэн нэр байсан бололтой.

Сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсгалд үсгийн хэлбэр адил буюу тун төстэй бичдэг энэ зүйлийг анхааралдаа авбал, “МНТ”-ы өөр хэсэгт байх ташаарлыг залруулж чадна. Жишээ нь: “МНТ”-ы 172-р зүйлд “... *so'or čölö-tür*”, 124-р зүйлд “... *nembe'e isgei bolju nemürleldün sorisu ...*” хэмээсэнд тохиолдож буй. “*so'or*” нь “*qo'or*” (*qoγar*), “*sorisu*” нь “*qorisu*” болохыг мэдэж болно. Энэ мэт баримт олныг дурдаж болох бөгөөд хэлэх гол санаа бол “МНТ”-ыг хятадаар галиглагч бээр сонгодог монгол бичгийн өмнөх үеийн үсгийн тиг зурлагаар бичсэн эхийг гартаа барьж байсан гэдгийг байнга эргэцүүлэн санаж, XIII, XIV зууны үеийн монгол бичгийн дурсгалуудын бичлэгийн онцлогийг ямагт анхааран, адилтган жишиж байх нь чухал хэмээн өгүүлсэн болно.

3. “МНТ”-ы хэлийг судлахад, хожмын монгол сурвалж бичгүүд, ялангуяа Лу. “Алтан товч”-той харгуулах судлах нь нэн эрхэм болно. “МНТ”-ы 282 зүйлийн 233-ыг үндсэнд нь агуулсан Лу. “Алтан товч” бол “МНТ”-ы хэлийг судлахад үнэхээр үнэ цэнтэй болох нь бидний эх бичгийн харьцуулсан судалгаанаас харагдсан билээ. 2002 онд “МНТ”, Лувсанданзаны “Алтан товч”-ийн эхийн харьцуулсан судалгаа” хэмээх номоо хэвлүүлж, судлаачдын хүртээл болгосон тул энд давтан өгүүлэх хэрэггүй буй заа. Харин XVII зууны түүхч Лувсанданзанд “МНТ”-ы ямархүү эх байсан тухайд цөөн зүйл өгүүлбэр. Бидний харьцуулсан судалгаанаас үзэхэд, XIV зууны сүүл үед “МНТ”-ыг хятадаар галиглагч хүний гарт байсан эхтэй адил төстэй, сонгодог монгол бичгийн өмнөх үеийн бичгийн хэвтэй, элж хуучирсан судар эх байсан нь тодорхой юм. Энэ тухай Мажарын нэрт монголч эрдэмтэн Л. Лигети бээр “*Lubsangdanjin used a manuscript of Secret History which preserved the orthographic and linguistic characteristics of the 13th century original in Uighur script*”⁸ (Лувсанданзан 13-р зууны зөв бичих зүйн болон хэлний онцлогийг хадгалсан “Монголын нууц товчоон”-ы уйгуржин монгол үсгийн гар бичмэлийг ашигласан) хэмээн бичсэн бөгөөд профессор Ш.Озава, профессор Х.П. Фийцэ нар мөн адил саналыг дурдсан байдаг.

Анхаарал татах нэгэн зүйл бол Лувсанданзанд байсан “Монголын нууц товчоон”-ы эх судар нь хятад галигаар бидэнд уламжилсан “Монголын нууц товчоон”-ы 268-р зүйл хүртэл буюу Чингис хаан тэнгэрт хальсан тухай өгүүлээд дуусч байжээ. Нэрт монголч эрдэмтэн И.Рахевилц тэргүүтэй эрдэмтдийн батлан бичсэнчлэн 1228 онд бичсэн эх зохиолын гол хэсэг нь ийм л агуулгатай байсан буй заа. Уг зохиол нь бараг “Чингис хааны узуур” хэмээсэн нэртэй байсан болов уу. “Монголын нууц товчоон”-той Лу. “Алтан товч” -ийг харьцуулан судлах нь “Монголын нууц товчоон”-ы хэлийг зөв ухаарахад туслахаас гадна Лу. “Алтан товч” -ийн өөрийн нь алдаа мэдгийг залруулахад боломж олгодог юм. “Монголын нууц товчоон”-ы хятад галиг эхэд “*s*”, “*q*” үсгүүдийг хооронд нь эндүүрсэн зүйл байдаг бол Лу. “Алтан товч” -д мөн эндүүрэл байхыг үзэж болно.

“Монголын нууц товчоон”-ы 147-р зүйлийг Лу. “Алтан товч” -той харьцуулбал:

[SHM] tere üge-tür jebe ügelerün aliba de'ereče

⁸ Igor de Rachewiltz “*The Secret History of the Mongols*”, Leiden Boston, 2004, pp. IVII

[LAT] tere üge-tür jebe ügelerün ayulan degere-ece
 [SHM] bi qarbula'a edö'e qa'an-a ükü'ülde'esü
 [LAT] bi qarbuluy-a edüge qayan namayi ükü'üldebesü
 [SHM] halyan-u tedüi qajar hō'ejü **qoçorsu**....»
 [LAT] alyan-u tedüi qajar-a üküjü **qoçurqu**....»⁹

хэмээсэн байх бөгөөд хойнох, өмнөх хэсгээс нь, утга давтсан мөр бадгаас нь үзвэл, “qoçurqu” бус “qoçursu” байх нь зөв байна. Өөрөөр хэлбэл, “Монголын нууц товчоон”-ы хятад галигийн эхийнх зөв юм. Ийм баримт олон буй.

Ерөнхийлөн багцалж өгүүлбэл, хятадаар галигласан “Монголын нууц товчоон” бол уйгуржин монгол бичгээр байсан эхийг XIV зууны дорнот монголын аялгуутан хүн бээр дуудлагаараа, өөрийн уншилтаараа буулгасан эх бөгөөд харин Лу. “Алтан товч” бол “Монголын нууц товчоон”-ы уйгуржин монгол бичгээр байсан судраас, XVII зууны монгол бичгийн хэв хэлбэрээр хуулан буулгасан эх юм.

4. “Монголын нууц товчоон”-ы хэлийг судлахад, уг зохиолын эхийн судалгаа, зүй тогтолтой байх хэл найруулгын онцлогийг бүхэл бүтэн зохиолын хэмжээнд анхааран үзэх ёстой бололтой. Тийм өвөрмөц тогтолцоотой онцлогийг олж мэдвэл, “Монголын нууц товчоон”-ы цөөнгүй хэсгийг зөв ухаарч, зөв хөрвүүлж, зөв орчуулах болно. Жишээ нь:

“Монголын нууц товчоон” эхлэнгүүт “de'ere tenggeri-ece jaya'atu töreksen borte-činö aju'u gergei inu qo'ai- maral aji'ai tenggis ketüljü ireba onan- müren -nū teri'ün-e burqan-qaldun-na nuntaqlaju töreksen batačiqan aju'u...” (Дээр тэнгэрээс заяат төрсөн Бөртэ-чино ажгуу. Гэргий инү Хоо марал ажээ. Тэнгис гэтэлж ирэв. Онон мөрний тэргүүнээ, Бурхан халдунаа нутаглаж төрсөн Батачихан ажгуу)¹⁰ гэж буй. Энэ хэсэгт Бөртэ-чино Хоо марал хоёр тэнгис далай гаталж, Онон мөрний эхэнд чухам тодорхой өгүүлбэл Бурхан Халдунд нутагласан ажээ.

“Монголын нууц товчоон”-ы 97-р зүйлд:

“... bürgi-ergi-de бүкүй-түр burqan-qaldun-ača uriangqadai gū'ün jarčiudai ebügen kü'ürge-ben ürcü jelme neretü kö'ün-iyen удуритчу ирежү” (Бүрги эрги-д бүхүйд Бурхан халдунаас урианхайдай хүмүүн Жарчиудай өвгөн хөөргөөн үүрч Зэлмэ нэрт хөвүүнээ удирдаж ирэж)¹¹ хэмээжээ. Энэ хэсэгт Бурхан халдунаас дарханы хөөргө үүрч, Зэлмэ хүүгээ дагуулан ирсэн хүн бол нэгдүгээрт Урианхай аймгийн хүн, тэр дотроос Жарчиудай нэртэй өвгөн хэмээн тодотгон лавшруулж өгүүлэхэд давталтыг хэрэглэжээ.

“Монголын нууц товчоон”-ы 24-р зүйлд:

“... bodončar ... baljun-aral gürčü tende ebesün nembüle ger kijü tende aba sa'uba” (... Бодончар... Балжун-арал хурч, тэнд өвсөн нэмбүлэ гэр хийж тэнд ав, суув.)¹² Энэ хэсэгт, өгүүлбэрийн өгүүлэхүүн гишүүнийг ойролцоо утгатай хэлзүйн үгээр давтан бичиж, Бодончарыг Балжун аралд тогтвортой сууршин амьдарсныг тодотгон өгүүлжээ. Энд “байх, суух” хэмээх хоёр үгийн утгын ялгамжаар байнга оршин суух болов хэмээсэн санааг шат ахиулан тодосгон өгүүлэхэд уг давталтыг хэрэглэжээ.

“Монголын нууц товчоон”-ы хэлэнд дан үгийг давтан хэрэглэсэн жишээ тохиолдож байна. Тэрхүү давталт нь өөр үгээр солих буюу товчилж үл болох агуулгатай байна. Жишээ нь:

“Монголын нууц товчоон”-ы 121-р зүйлд:

“... jamuqa-yi horčiju yabuju ger tergen inu mürgüle'et ... jamuqa-yi mürgüjü öre'ele eber-iyen ququraju soljir ebirtü bolju eber minu ača ke'en ke'en jamuqa-yin jük mō'ören mō'ören siro'ai sačun sačun bayimu...” Жамуха-ыг орчиж явж, гэр тэргийг инү мөргөлөөд ... Жамухыг мөргөж, өрөөл эврээн хугалж, солжир эвэрт болж, эврийг минь ац хэмээн хэмээн Жамуха-ын зүг мөөрөн мөөрөн шороо сацан сацан баймуу...)¹³ хэмээжээ. 1957 оны Ц.Дамдинсүрэн гуайн “МНТ”-ы

⁹ Ш.Чоймаа, “МНТ”, Лувсанданзаны Алтан товч, эхийг харьцуулсан судалгаа”, УБ 2002.т 96

¹⁰ Rachewiltz Igor de, Index to the Secret History of the Mongols, Bloomington, 1972, 13-р тал

¹¹ мөн номын 37-38-р тал.

¹² мөн номын 17-р тал.

¹³ Rachewiltz Igor de, Index to the Secret History of the Mongols, Bloomington, 1972, 50-р тал

орчуулгад “Жамуха-ыг тойрон явж Жамуха ба гэр тэргийг нь мөргөсөөр өрөөсөн эврээ хугалж, солжир эвэртэй болоод “эврийг минь өг” хэмээн Жамуха-ын зүг мөргөж, шороо сацан баймуй...” гэжээ. Энд гарч байгаа үг бол Жамухатай “хээль нэгтэн, хэхэй ганцтан” Хорчи бээр Тэмүжинд нэгдэн ирж, “тэнгэр газар эетэлдээж, Тэмүжинийг улсын эзэн болтугай” хэмээн тэнгэрийн хэлмэрч заарин нугууд нүдэнд үзүүлэн зааж, мөн тэнгэрийн элч хуагчин үнээ, Жамуха-ыг үл бүтэх нөхөр хэмээн заалаа гэдгийг бат нут болгон дүрслэн тодосгож өгүүлэхэд дээрх үгсийн давталт их хүч нэмж байна.

“Монголын нууц товчоон”-ы 134-р зүйлд:

“činggis qahan-na e'ün-eče yeke nere nemeküi-yi jeutau nere ökgü-yi altan qan medetügei...” (Чингис хаанаа, үүнээс их нэр нэмэхийг, Жау Тау нэр өгөхийг Алтан хан мэдтүгэй)¹⁴ хэмээжээ. Энд Чингис хааны Татаарын Мэгүжин Сүүлтийг барьсан ач гавьяаг үнэлж, Алтан хан их нэр цол өгөх, чухам тодруулбал, Жау Тау нэр цол өгч болохыг өгүүлжээ. Ийнхүү утгыг тодотгон давтахдаа, тийн ялгалын нөхцөлийг их төлөв хамт давтан хэрэглэсэн онцлог ажиглагддаг. Мөн “Монголын нууц товчоон”-ы 68-р зүйлд: “... yisügei- ba'atur ... čaqa minu mönglik... bi kö'ü-ben temüjin-i güriget-te talbiju iregün...” (Есүхэй баатар ... чагаа минь Мөнлиг ... би хөвүүгээ, Тэмүжинийг хүргэдэд тавьж ирэрүүн (ирэхдээ Ш. Ч) ...) ¹⁵ хэмээжээ. Энэ хэсэгт, “хөвгүүнээ” гэсэн нь аль нэг хүүтээ гэсэн утга, “Тэмүжинийг” гэвэл тэр хүү нь чухам Тэмүжин болохыг тодосгожээ. Ийм баримт “МНТ”-д тун олон бөгөөд ийм онцлог байдгийг мэдвэл, зарим маргаантай хэсгийг ч тодолж болно. Жишээ нь:

“МНТ”-ы 12-р зүйлд:

“hoi dоторa uriangqadai gū'ün čö'e buqu alaju qabirqas inu abit inu siraju bügü-yi jolqaju...” (Ой дотор Урианхайдай хүн чөх буга алж, хавиргас инү, абид инү шарж бүхүйг золгож)¹⁶ гэж буй. “abit” (абид) хэмээх үгийн талаар адил бус санал байдаг. Лу. “Алтан товч”-ийн хажуугийн нэмэлт бичвэрт “богино” гэсэн үг бий. Дээр эш татсаныг ажиглаж, утга лавшуулан тодосгон өгүүлдэг зохиогчийн найруулгыг бодолцвол, “abit” гэх нь “богино хавирга” болох нь тодорхой юм. Тэрхүү Урианхайдай хүн буга агнаад хавиргыг нь шарж идсэн, чухам ямар хэсгийг нь шарсан бэ? гэвэл, “abit” буюу цоройт богино хавиргыг шаржээ. Энгийн логик, учир шалтгаанаар бодсон ч, ан агнасан хүн, хамгийн амархан шарж болох хэсгийг сонгох нь мэдээж хэрэг тул богино хавиргыг цоройн хэсэгтэй нь огтлон авсан нь мэдээж хэрэг.

Төгсгөлд дүгнэхэд, “МНТ”-ы хэлийг сайн судлахад, “МНТ”-ы хэлний нарийн ширийн зүйл, үг үсэг, дагавар нөхцөлийн хэв байр, холбоо үг, өгүүлбэрийн онцлог зэргийг эхийн төвшинд, бүрэн хэмжээгээр шүүн үзэж, тэдгээрийн утга үүргийг тодруулах, үүргийн зүй тогтолтой, дахин давтагддаг шинж байдлыг тодлох ёстой юм.

SUMMARY

Analyzing the language of the ‘Secret History of the Mongols’, words, place of suffixes, compound words and features of sentences have been entirely examined in the textual level. Their semantic functions and regularity in function need to be defined.

¹⁴ мөн номын 57-р тал.

¹⁵ мөн номын 26-р тал.

¹⁶ мөн номын 14-15-р тал.